

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2022.12.20

Нэг. Ерөнхий мэдээлэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өглөө.

Хоёр. Үнэлгээний дүн

Нийгмийн даатгалын ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2022 онд 10 зорилтын 67 арга хэмжээ туссанаас нийт арга хэмжээний хэрэгжилт 92.5 хувь буюу **"тодорхой үр дүнд хүрсэн"** гэж үнэлэгдлээ. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 13 арга хэмжээ;
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 1 зорилт, 22 арга хэмжээ;
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 4 зорилт, 17 арга хэмжээ;
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилт, 15 арга хэмжээ байна.

Гурав. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт

- Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд хүрсэн, үр дүн нь гарсан /100 хувь/ арга хэмжээ – 49;
- Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа /90.0 хувь/ арга хэмжээ - 6;
- Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа /70.0 хувь/ арга хэмжээ -7;
- Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн /50.0 хувь/ арга хэмжээ- 4 байна.
- 1 арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.

Дөрөв. Үр дүнтэй хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд

- Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар 2022 онд 3,300.8 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаас 3,445.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, төлөвлөгөөг 104.4 хувиар биелүүлсэн байна.
- 2022 онд 49.3 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. Үүнээс: 12.3 мянган малчинтай сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах ажлыг зохион байгуулсан байна.
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500,0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400,0 мянган төгрөгт хүргэж ажилсан байна.
- Шинээр даатгалд хамруулах ажил олгогч, даатгуулагчийн тоог тусгаж, 2022 онд 4.4 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн даатгалд шинээр хамруулж, 134.1 мянган иргэнийг албан журмын даатгалд хамруулсан байна.

Тав. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүд

- Нэрийн дансны хүүгийн хэмжээг тооцон, Үндэсний статистикийн хорооны саналыг авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулсан байна.
- Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар баталсан нийгмийн даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягыг Үндэсний статистикийн хороотой хамтран шинэчлэн боловсруулах;
- 2023 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр, сар, улирлын хуваарийг баталж төв, орон нутгийн албадад хүргүүлсэн байна.
- Ажил олгогчоос тоон гарын үсгээр илгээсэн тайланг хүлээн авах ажлыг өргөжүүлсэн байна.

Зургаа. Зөвлөмж

- Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тоот тушаалыг мөрдөж боловсруулах, тайлагнах
- Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, салбарын мэдээлэлд үндэслэх, арга хэмжээний хүрэх түвшин нь зорилтын үр дүнг илэрхийлсэн байх.

2023 оны төлөвлөгөөг боловсруулах талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгах;
- Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх;
- Зорилтот түвшин нь бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, зорилтын үр дүнг илэрхийлсэн байх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР